



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 2/316

Хэрлэн сум

Байгалийн аюулт үзэгдлийн улмаас  
үүссэн мал, амьтны сэг зэмийг цуглуулж,  
устгах ажлын зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60.1.21, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн зарим сумдын нутаг дэвсгэрт байгалийн аюулт үзэгдлийн улмаас үхсэн мал амьтны сэг зэмийг цуглуулж, устгах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Э.Мөнх-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн  
дарга:

Н.Анхбаяр

Мал эмнэлгийн газрын дарга

Гишүүд:

Ж.Энх-Амгалан

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Э.Мөнх-Эрдэнэ

Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын даргын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч

Д.Батхүү

Цагдаагийн газрын дарга, цагдаагийн  
хурандаа

Ц.Гэрэлмаа

Зооноз өвчин судлалын төвийн дарга

2. Мал амьтны сэг зэмийг цуглуулж, устгах ажлыг чанартай зохион байгуулж, 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусгахыг холбогдох бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан), Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ